



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/153

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1, Засаг даргын Мөрийн хөтөлбөрийн 4.3.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэсгийн төлөөлөгч болон цагдаагийн албан хаагчдийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор техник хэрэгслийн засварт зориулж 3 993 000 (гурван сая есөн зуун ерэн гурван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Уг зардлыг Засаг даргын Мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-т даалгасугай.

ДАРГА

Ц.БАТЦООЖ

